

## МОНГОЛ ТУУЛЬ ДАХЬ ЭМ МАНГАСНЫ ДҮРИЙН ИЛРЭЛ ГАРЛЫН АСУУДАЛД

Зуланцэцэг, магистр, ӨМИС

**Abstract:** The image of Mother Manggas is not much in comparison with Father Manggas which is the main negative image in Mongolian Epic, but the problem of the origin of the Mother Manggas is important subject yet in Image Study of folklore. In Mongolian Epic, Mother Manggas include Manggas's mother, Manggas's wife and Manggas's daughter. Academia generally considered that Mother Manggas is traditional image from the Mongolian culture. The descriptions of the image of Mother Manggas in the Mongolian Epic have fixed relatively. For example, while the Manggas's mother and Manggas's wife described as big belly, big breasts or more breasts, the Manggas's daughter described as the one-eyed or yellow hair. However, there is not the image of Mother Manggas in the part of the Mongolia history in Mongolian Historical Documents from the 13th century to the 20th century, there is the image of Father Manggas only in it, but we can find the image of Mother Manggas in the part of the Indian and Tibetan history in those Mongolian Historical Documents. And the descriptions of the image of Mother Manggas exactly like the Indian or Tibetan negative Mother images, such as Ragsasi, Avirahmo or Sinmo etc. Furthermore, it is a common phenomenon that the negative Mother images in the Indian or Tibetan Documents will translate into the Mother Manggas for Mongolian in History of Mongolian Translation. So the problem of whether the Mother Manggas is the traditional image from the Mongolian culture is controversial. In this paper, we will discuss the origin of the Mother Manggas from the relationship between Mongolian Epic and Mongolian Historical Documents.

**Түлхүүр үг:** монгол түүхэн сурвалж бичиг, эм мангас, рагшис, аврах эм, бурхан шашин

Эм мангасын дүр нь монгол туульд эсрэг талын гол дүр болох эр мангасын адил төдийлөн их гардаггүй боловч уг дүрийн гарал нь аман зохиолын дүр судлалд чухал сэдэв болно. Монгол тууль дахь эм мангасын дүрд мангасын эх, мангасын эхнэр, мангасын охин зэрэг хэдэн дүр байдаг.

Мангасын эх болон мангасын эхнэр зэрэг эм мангасын дүр нь ерөнхийдөө том гэдэстэй, том хөхтэй буюу олон хөхтэйгээр дүрслэгдэх нь түгээмэл агаад мангасын охин нь ганц нүдтэй, шар үстэй буюу шар төрхтэй дүрслэгддэг байна.

Эм мангасын гарлын асуудлыг судалсан эрдэмтэн Никлодов “Мангасын гэр бүл дэх эмэгтэйчүүдийн дүр нь эртний шидэт үлгэрт байдаг эм шуламс буюу уулдаа эм шуламс байгаад сүүлд нь эм сахиулсан-ээжийн олон зүйлийн хувилбар болсон байх ёстой”<sup>1</sup> хэмээжээ. Даруй эм мангас нь эртний шидэт үлгэр дэх эм шуламсын дүрээс гаралтай хэмээн үзсэн байна.

Эрдэмтэн В.Манлай “Монгол тууль дахь эм мангас нь гэрийн чинээ гэдэстэй, гэдгэр шар

1 谢.尤.涅克留多夫：《蒙古人民的英雄史诗》，内蒙古大学出版社，1991年5月。130-р хуудас.

эмийн дүрээр дүрслэгдэж, дотоод сэтгэл, хүч чадал зэргийг балар эртний эм бэлгийн шүтлэгтэй харьцуулан судлаад, уг дүр нь монголчуудын шүтээн-этүгэн эхийн байдал төрхийн дүрслэл зураглал болно” гэж үзжээ (Манлай, 1995).

Эм мангас нь Монголчуудын этүгэн эхийн дүрээс гаралтай буюу уг дүрийн монголын соёлын түүхэн дэх эрт язгуур шинжийг өгүүлсэн болно. Монгол тууль дахь эм мангасын дүрийн гарлын хувьд дээрх хоёр эрдэмтний бүтээлээс өөр судалгааны бүтээл байхгүй боловч уг дүрийг Монголын соёл дахь уламжлалт дүр буюу монгол хөрсөнд бий болсон дүр хэмээн нийтэд хүлээн зөвшөөрөгддөг байна. Гэхдээ соёлын түүхийг өгүүлсэн сурвалж бичгүүдэд зөвхөн эр мангасын дүр дүрслэгддэг учир монгол тууль дахь эм мангас нь уламжлалт дүр мөн эсэх асуудлыг тодруулах шаардлагатай байна. Ийнхүү монгол тууль болон түүхэн сурвалж бичиг дэх эм мангасын дүрийг харьцуулан судалсны үндсэн дээр уг дүрийн гарлыг тодруулах зорилго тавьяа.

Монгол туульд эм мангасын дүр нь нэлээд хэвшмэл дүрслэлтэй байдаг боловч XIII-XX зууны үеийн түүхэн сурвалж бичгүүдэд дүрслэгддэг мангас нь хүйсийн ялгаатай дүрслэгдсэн нь бий.

Мангасын дүрийг зөвхөн эр хүйсийг төлөөлүүлж дурдсанаас бус эм хүйсийг дурдаагүй байна. Үүний учир нь нэгд, уг дүр нь голдуу догшин ширүүн, хатуу харгис, ид шидийн байдлаар дүрслэгддэг. Жишээлбэл, Өүлэн Үжингээс дүү Бэгтэрийг харван алсан Тэмүжин болон Хасарыг “Амьд залгису гэх мангас мэт” (Монголын нууц товчоо, 1981, х.150) хэмээн шүүмжлэх, Жамуха Хасарыг “Хүн хүнээс бус, гүрлэх мангас төрсөн” (Монголын нууц товчоо, 1981, х.840) хэмээн Наян хаанд дүрслэн өгүүлэх, Даян ноёныг “Урьд цагтаа хилэнцэнээ дуртай, сэтгэл хатуу мангас мэт хүн аж” (Жамбадорж, 1984, х. 471) хэмээн дүрслэсэн зэргээс харж болно.

Хоёрт, уг дүр нь эрэгтэй хүний нэрээр нэрлэгдсэн байна. Жишээлбэл, “Лигдэн хутагт хааны эцэг, Байсгал хөндлөн хааны нэг хөвгүүн, Үнэндарийн нэг хөвгүүн, Буяндар Хулачи баатрын нэг хөвгүүн, Хорчины Уубагийн авга эцэг зэрэг таван хүн мангас гэдэг нэртэй байхаар түүхэнд үлдсэн байна” (Зуланцэцэг, 2013). Ийнхүү хүч чадалтай, догшин ширүүн зантай, дайн байлдааны гавшгай баатрын дүрээр дүрслэгддэг мангас нь эр хүйсийг зааж байгаа нь тодорхой болно.

Монголын домог туулиас харвал мангасын хүйсийн байдлыг тодруулж ярих шаардлага байхгүй бөгөөд монголын уламжлалт дүр дүрслэлд мангас нь зөвхөн эм хүйстэй байгаагүй гэдгийг тодруулж байна. Даруй монголын соёлын түүхэн дэх мангас хэмээх дүр нь гэр бүлгүй, үр хүүхэд ч байхгүй гэдгийг нотолж болно. Ийм ч учраас монгол туульд мангас нь хатантай болохын тулд хэн нэгэн баатрын хатныг булаахаар тэмцэлдэж буй байдлаар илэрдэг. Даруй мангас нь ганц бие дүрслэгдэх болсон нь монгол туульд хатан булаах сэдэв буй болоход нөлөөлсөн байна.

Монгол туульд мангас нь зөвхөн баатрын хатныг булааж эхнэртэй болох биш, мангас өөрийн хатантай байх бөгөөд үр хүүхэд олонтой болж туулийн дүрийг баяжуулж байна. Монгол туульд эм мангасын дүр бий болсон нь Энэтхэг, Төвдөөс бурхны шашны монгол орон дахь дэлгэрлийг дагалдан түүхэн сурвалж бичиг, “Панчатантра” болон төвд “Гэсэр” зэрэг туулийн нөлөөлөл орчуулгаар дамжин монгол соёлд нэвтэрсэн юм. Энэхүү асуудлыг монгол үлгэр, домог дахь Энэтхэг, Төвдийн эм мангасын дүрээр баримт болгон нотолж болно.

Монгол үлгэр домгийн Энэтхэг, Төвдийн домгийн хувилбарт мангас нь хүйсийн ялгаатай

байдаг. Жишээлбэл “Болор толь” дахь эртний энэтхэгийн тууль “Рамааяна”-гийн товч агуулгыг өгүүлсэн хэсэгт “Тэр цагт мангасын орноо мангасаас нэгэн гайхамшиг охин төрснөө ... энэ охин мангасын орныг хоосон болгох шинжтэй буй” гэсэн өгүүлэмж байдаг (Жамбадорж, 1984, х.42). Энэ жишээнд “мангасын охин” гэх эм мангасын дүр буй. “Рамааяна” дахь мангас нь Энэтхэгийн домгийн дүр болох рагшисийн монголжуу орчуулга болно. “Рагшисын дүр нь мангасын дүртэй нэлээд ойролцоо байдаг тул Монголчууд “рагша (буюу рагшис)” гэж авиачилан орчуулахаас гадна олонхдоо мангас гэж орчуулж байсан юм” (Мөнхзаяа, 1988).

Нэгэн жишээ татвал, “Субашид”-ийн Монгол орчуулгад XIII зууны эхнээс XIII зууны сүүлч үед амьдарч байсан Суманкара (Гунгаажалцан, 1989, х.60) “Даса хирийн Ланкад алагдсан” гэх бүлгийг “жаргаланд хурьцсаны шалтагаар, Даш хирви (Даса хири) Ланкад алагджээ” гэж орчуулж (Мөнхзаяа, 1988, х.165), XVII зууны сүүлчээр амьдарч байсан Данзанчойжигоос “хүсэлд шунасан шалтгаанаар, Ланкабарын Дашхирва алагдвай гэх” хэмээн орчуулж байхад (Мөнхзаяа, 1988, х.166), Лувсанчүлтэм (1740-1810) “олз хүсэл их шунасны гэмээр, урьд мангасын нэгэн хаан Ланкад алагдсан үлгэр мэт” хэмээж (Мөнхзаяа, 1988, х. 63), Дамбижалцан (1730-1780)-гаас “тачааж шунасны уршигаар мангасын, габовад гровагс (бод-дрог) Ланкад хаан нь алагдав хэмээгдвэй” хэмээн (Д.Мөнхзаяа, 1988, х.166), XVII зууны үед “Ганжуур”-ыг монголчлох ажилд оролцож байсан Чойжамц-аас “дурлан шүлхийдсэний шалтгаанаар (Мөнхзаяа, 1988, х.165), Дашхарива хэмээх мангас алагдвай” (Д.Мөнхзаяа, 1988, х.166) гэж тус тус орчуулсан байдаг (Мөнхзаяа, 1988, х.166).

Эдгээр орчуулгаас үзвэл “Даш хири” гэдэг дүрийг “Даш хирви”, “Дашхирва” гэж байснаасаа XVII зуунаас эхлэн “мангас” хэмээн орлуулан орчуулах болжээ. Үүний тухай Лувсанчүлтэм бээр “мэдэхэд хялбар болохыг эрхлэн шинжлээд өөрийн оюунд ургасаны хирээр ... бичив” хэмээн тайлбарлав (Д.Мөнхзаяа, 1988, х. 163).

Ийнхүү “Болор толь” дахь мангасын охин нь үнэндээ рагшисын охин бөгөөд, уг дүр нь монгол соёл дахь мангасын охинтой зөвхөн орчуулгаар дамжин нэрийн хувьд л нэгдсэнээс биш, агуулга утгын хувьд зөрөөтэй ойлголт юм. Рагшисын охины дүрийг монгол ахуйд тохируулж орчуулсан явдал нь Монгол туульд мангасын охины дүр

буй болоход зохих ёсоор нөлөөлсөн хэмээн үзэж болохоор байна.

“Болор толь” дахь Төвдийн түүхийг үзүүлсэн хэсэгт “Анх төвд орон гол болгох газар нь эм мангасын гэдрэг хэвтсэн мэт шинжтэй. Үүний шүтэн барилдлагаар төвд орны улсад цэрэг дайны аюул олон гарах, хүн улсын сэтгэл хатах хэмээдэг... эм мангас хэвтсэн мэт газрын мөч гишүүн бүгд дээр урьд сүм барих хэрэгтэй хэмээж, Гр (Да) бүрэг эхлэн зүг зүгт арван хоёр сүм баривай. Жич бас муу шинжтэй газарт даруулгыг олонтаа хийвэй” хэмээв (Жамбадорж, 1984, х.267-278). Энэхүү агуулгыг нь төвд сударт тэмдэглэсэн байсныг эрдэмтэн Чойжи бээр тэмдэглэв.

Төвдийн нэг сударт өгүүлснээр, Балбын газраас ирсэн Чизүн хатан (Цагаан дарь бодьсун) бээр Хятадын газраас ирсэн гүнж хатан (Ногоон дарь бодьсун)-ыг зурхайн ухаанд мэргэн хэмээснийг мэдэж хүн зарж аль газар сүм бүтээвээс сайн буюу хэмээн асуулгасанд, гүнж хатан бичиг үзэж, цастны орон Төвдийн газрыг шинжээд, цастны орон төвд хэмээгч нь аврах эм (зарим монгол сударт мангас хэмээн орчуулж, хятад сударт 刹女 буюу 女魔 хэмээн орчуулан буй) гэдрэг хэвтсэн адил шинжтэй, энд бүхий Оодангийн нуур хэмээгч нь тэрхүү гэдрэг хэвтсэн аврах эмийн зүрхний цусан мэт газар хэмээгээд тэрхүү аврах эм гэдрэг хэвтсэн мэт газрын мөч гишүүн бүгд дээр сүм барьж, бас Оодангийн нуурыг оромгүй болгон дээр нь шүтээн тахиваас сая төвд орноо бурхны шашин дэлгэрэх болмуй хэмээсэн гэдэг. Тэндээс аврах эм гэдрэг хэвсэн мэт газрын мөч гишүүн хэмээгдсэн хоёр мөр хоёр сүүжид дөрвөн сүм, хоёр тохой өвдөгт дөрвөн сүм, хоёр гарын алга, хоёр хөлийн уланд дөрвөн сүм, нийт арван хоёр сүм бүтээвэй гэх” хэмээв (Чойжи, 1998, х. 28-29).

Төвд судар дахь “аврах эм” гэдгийн “аврах” гэгч нь уул төвд үгийнх нь авиачилсан орчуулга байх ёстой. Шалтгаан нь монгол хэлэн дээр “аварга” гэдэг авиатай тохиролцох дүр огт байхгүй юм. Харин “эм” гэдэг нь төвд хэлний хүйсийг заадаг “mo” хэмээх үгийн утгачилсан орчуулга байх ёстой. Энэхүү үгсийн бүтэцтэй адилхан нэг жишээг татвал, “(sin mo) (шулам) гэдэг үг төвд хэлэнд эм мангасыг заадаг бөгөөд “mo” гэдэг нь эм хүйсийг заадаг. Эр мангасыг төвд хэлэнд (sin

bo) гэдэг (Боржигон Чулуу, 2016). Ийнхүү “аврах эм” хэмээх нь төвдийн нэг дүрийн авиачилсан болон утгачилсан орчуулгын тайлбар болох нь тодорхой байна.

Эрдэмтэн Чойжи бээр “аврах эм” гэдэг нэрийн доор бас өөрийнхөө тайлбарыг хийсэн байдаг. Тэрбээр “зарим монгол сударт мангас хэмээн орчуулж, хятад сударт 刹女 буюу 女魔 хэмээн орчуулан буй” хэмээжээ. Тэгэхээр “Болор толь” дахь “эм мангас” хэмээх нь “аврах эм”-ийн монголжуу орчуулга байх ёстой юм. 刹女 хэмээх нь эм рагшис (raksasi)-ийг хэлдэг, эм рагшис хэмээх нь Энэтхэгийн рагшис хэмээх дүрийн эм хүйс нь болно. Дээрх жишээнүүдийг үзвэл, Энэтхэгийн эм рагшис, Төвдийн аврах эм болон шулам, Монголын эм мангас зэрэг нь Энэтхэг Төвд, Монгол судруудын орчуулга дахь нэг дүрийн олон хэлэн дэх орчуулгууд мөн. Эдгээр орчуулга нь монгол туульд эм мангасын дүрийн үүсэн буй болоход анхны суурийг тавьсан байна. Даруй, эм мангасын дүр нь бурхны шашны монгол оронд хүчтэй дэлгэрсэн XVII зууны үеэс Энэтхэг, Төвдийн үлгэр домгийн дүрүүдийн нөлөөгөөр монгол туульд бий болжээ.

## ДҮГНЭЛТ

Монгол үлгэр, туульд дүрслэгддэг мангасын дүр нь хүйсийн ялгаатай байдлыг төдийлөн дүрслээгүй боловч эрч зориг, хүч чадлыг дүрсэлсэн нь эр мангасыг зааж байна. Даруй монгол домог туульд эм мангасын дүр байхгүй юм. Монголын уламжлалт соёлд эм мангасын дүр байсангүй бөгөөд туульд мангас баатрын хатныг булаах сэдэв бий болсон хэмээн үзэж болмоор байна.

Монгол түүхэн сурвалж бичгүүдийн Энэтхэг, Төвдийн хэсэгт илэрсэн эм мангасын дүр нь монголын уламжлалт дүрслэл биш юм. Уг дүр нь Энэтхэг, Төвдийн эм рагшис, аврах эм, шулам зэрэг дүрүүдийн монголжуу орчуулга болно. Үүнээс үзвэл мангасын дүр нь бурхны шашны хүчтэй дэлгэрсэн XVII зууны үеэс Энэтхэг, Төвдийн үлгэр домгийн дүрүүдийн нөлөөгөөр монгол туульд буй болж, хэдэн зуун жилийн туршид хэвшсэн дүрслэлтэй болж төлөвшсөн байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Баяр. (орч). (1981. 1 сар). *Монголын нууц товчоо (дээд)*. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо

Боржигон Чулуу. (2016). “Буриадын Т.Галсанжамбын орчуулсан рашааны дусал” нь Цахар гэвшийн орчуулгыг хэрхэн засаж хэвлүүлсэн тухай асуудалд. *Өвөр монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл*.

Гунгаажалцан. (1989. 9 сар). Сайн үгт эрдэнийн сан нэрт шаштир, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо

Жамбадорж. (1984. 5 сар). *Болор толь*. Үндэстний хэвлэлийн хороо

Манлай, В. (1995. 3 сар). Монгол туульс дахь гэрийн чинээн гэдэстэй гэдгэр шарэмийн дүр бүтээлгэ. *Өвөр монголын багшийн их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл*.

Мөнхзаяа, Д. (1988. 1 сар). Мангасын үлгэр дэх энэтхэг төвд ирэлттэй хэдэн мотив. Монгол хэл утга зохиол. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо

Чойжи. (1998. 11сар). “Монголын бурхны шашны түүх -Их монгол улсын үе (1206-1271)”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо,

【奥地利】勒内·德·内贝斯基·沃杰科茨 □ □ 西藏神灵和鬼怪 □ □ 西藏人民出版社 □ 1993年5月。

【德】格塞著：《艺术的起源》，商务艺术出版，1994年5月。

龙：《鳞古思故事》，北京范大学出版社，2003年。

【法】保里克尔：《的象征》，上海世出版社，2005年4月。

潘道正：《丑的象征-从古典到代》，广西范大学出版社，2012年3月。